

2008.06.12

Дугаар 161

“Атар чандган” ХК-ийн үнэт цаасыг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмын 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1.“Атар чандган” ХК-ийн 114796 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “МХБ” ХК /Р.Содхүү/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжаас хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2.Компани хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан компанийг өөрчлөх төсөлд заасан арга хэмжээ болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Атар чандган” ХК /Б.Энхтөр/-д үүрэг болгосугай.

3.Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ